



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А1453

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын “Оюуны эрин” сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дэлхийн зөн” олон улсын байгууллагаас хандивласан нийт 12,799,161.00 (арван хоёр сая долоон зуун ерэн есөн мянга нэг зуун жаран нэг) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын “Оюуны эрин” сургууль (Б.Амгалан)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын “Оюуны эрин” сургууль (Б.Амгалан)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн Д/Б дугаар тушаалын хавсралт

Бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн ерөнхий боловсролын "Оюуны эрин" сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Үйлдвэрлэсэн он	Цанар байдал	Хэмжээ	Бүртгэх анхны		Хандивлагч байгууллага		
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	нэр	Эх үүсвэр	
1	Төмөр шүүгээ 12 хаалгатай		Саарал өнгөтэй	2024	шинэ	ш	2	830,000.00	1,660,000.00	Дэлхийн Зөн ОУБ	Хандив
2	Төмөр шүүгээ хувцасны 3		Саарал өнгөтэй	2024	шинэ	ш	1	630,000.00	630,000.00		
3	Уулзалтын ширээ		Хүрэн модон	2024	шинэ	ш	1	863,300.00	863,300.00		
4	Саарал сандал		Саарал өнгийн	2024	шинэ	ш	20	134,830.00	2,696,600.00		
5	Буйдан сандал бор		Бор өнгийн	2024	шинэ	ш	2	468,000.00	936,000.00		
6	Шилэн хар ширээ		Хөлтэй	2024	шинэ	ш	1	100,000.00	100,000.00		
7	Номын тавиур төмөр		Саарал өнгөтэй	2024	шинэ	ш	1	100,000.00	100,000.00		
8	Түшлэгтэй сандал саарал		Хөх өнгийн	2024	шинэ	ш	2	538,350.00	1,076,700.00		
9	Шилэн хаалгатай шкэф		Шаргал модон	2024	шинэ	ш	1	1,135,341.00	1,135,341.00		
10	Сэтгүүлийн ширээ		Гурвалжин жижиг	2024	шинэ	ш	1	209,520.00	209,520.00		
11	Ажлын ширээ шаргал		Шаргал модон	2024	шинэ	ш	1	310,400.00	310,400.00		
12	Ажлын сандал дугуйтай		хар түшлэгтэй	2024	шинэ	ш	1	281,300.00	281,300.00		
		Тавилга эд хогшил						9,999,161.00			
1	Ус шүүгч	Water Care	Балонтой	2024	шинэ	ш	2	850,000.00	1,700,000.00		
2	Гар хатаагч	Inerhasai	Суурин	2024	шинэ	ш	2	550,000.00	1,100,000.00		
		Машин тоног төхөөрөмж						2,800,000.00			
		Нийт дүн					38		12,799,161.00		